



УЛААНБААТАР  
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИЙ  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/44

Улаанбаатар хот

Зураг төсөлд тодруулга хийх,  
зөвшилцөх журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 204 дүгээр тогтоол “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм”-ийн 5 дугаар зүйл, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.11, Гүйцэтгэх захирлын 2013 оны А/20 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн тушаах нь:

1. Зураг зөвшилцөх журмыг шинэчлэн хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Техникийн асуудал эрхэлсэн дэд захирал /Р.Дагдан/-д даалгасугай.
3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан гүйцэтгэх захирлын 2015 оны А/55 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАГ



Д.БАЯРСАЙХАН



Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн  
Гүйцэтгэх захирлын 2017 оны 08 дугаар сарын 23-ны  
өдрийн 1144 дугаар тушаалын хавсралт



## 1. ЗОРИЛГО

“Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм”-ийн 5 дугаар зүйлд заасныг үндэслэн тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн боловсруулсан гадна цахилгаан хангамжийн болон бусад инженерийн байгууламжийн зураг төслийг зургийг зөвшилцөхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

## 2. ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧГҮҮД

- 2.1 Эрчим хүчний тухай хууль.
- 2.2 Засгийн газрын 2012 оны 151 дүгээр тогтоолын хавсралт “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх ашиглалтан оруулах дүрэм”-ийн тавдугаар хавсралт “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, ашиглалтанд оруулах үйл ажиллагааны жагсаалт”.
- 2.3 “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм.”
- 2.4 “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн үйл ажиллагааны дэг жаяг.

## 3. ХАМРАХ ХҮРЭЭ

- 3.1 Энэхүү журмыг Улаанбаатар хотын 8 дүүрэг, Төв аймгийн 16 сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд дагаж мөрдөнө.

## 4. МӨРДӨХ АЖИЛТНУУД

- 4.1 “УБЦТС” ТӨХК –ийн ажилтнууд.
- 4.2 Зураг төслийн ажил эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд.

## 5. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 5.1 Зураг төсөл зохиогч нь хамгийн сүүлийн байдлаар мөрдөж байгаа Цахилгаан байгууламжийн дүрэм, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс олгосон техникийн нөхцөл, Техникийн шаардлагын тодорхойлолт (ТШТ), шугамын трасс ба дэд станцын талбай сонгож зөвшилцсөн акт, зургийн даалгаврын дагуу зураг төслийн эхний хувилбарыг хийж “УБЦТС” ТӨХК-ийн Түгээх төвүүдээс тодруулга авч тусган, зөвшилцөл хариуцаж буй нэгжтэй зөвшилцсөний үндсэн дээр зураг төслийг боловсруулна.
- 5.2 Зураг төслийн тодруулга, зөвшилцөх ажлыг “УБЦТС” ТӨХК нь Монгол улсын Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хугацаанд багтааж зохион байгуулна. Дэвсгэр зураг нь шинэчлэгдээгүйн улмаас зураг төслийн байгууллагад буцаасан болон зураг төслийн байгууллагаас болж үүссэн хүлээлт энэ хугацаанд орохгүй.
- 5.3 Компанийн зүгээс зураг төслийн тодруулга, зөвшилцөл, зөвшилцлийг баталгаажуулах ажил нь “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм” –ийн 3.1-д заасан зураг төслийн бэлтгэл ажлын хүрээнд хамаарах бөгөөд зураг төсөлтэй холбоотой хариуцлагыг зураг төслийн



байгууллага, зургийн автор нар хүлээнэ.

## 6. ЗУРАГ ТӨСӨЛД ТОДРУУЛГА ХИЙХ

- 6.1 Зураг төслийн гүйцэтгэгч нь Техникийн нөхцөлийн дагуу боловсруулсан шугамын трассын болон дэд станцын байрлалын зургийг харъяа түгээх төвийн Мэдээллийн сангийн инженерт хүлээлгэн өгнө.
- 6.2 Зураг төсөлд тодруулга хийлгэх хүсэлт гаргахдаа дараах баримт бичгийг бүрдүүнэ. Үүнд:
  - 6.2.1 Техникийн нөхцөл.
  - 6.2.2 Ажлын зураг.
- 6.3 Мэдээллийн сангийн инженер нь дараах тодруулгуудыг хийж зурагт тоогоор тэмдэглэн “Зураг төсөлд тодруулга хийсэн тодорхойлолт”-д тайлбар бичиж гарын үсгээр баталгаажуулж гүйцэтгэгчид өгнө.
- 6.4 Мэдээллийн сангийн инженер нь тодруулга хийсэн зураг төслийг электрон сан үүсгэх замаар Түгээх төвийн дарга, Ашиглалт үйлчилгээний хэсгийн ахлагчийг мэдээллээр хангана.
- 6.5 Тодруулга хийлгэх дэвсгэр зураг нь 6 сараас дээшгүй хугацааны өмнө шинэчлэгдэж мэдээллийн санд бүртгэгдсэн кабель шугамд 1:500-аас багагүй, агаарын шугамд 1:1000-аас багагүй масштабтай байх ёстой.
- 6.6 Тодруулгад дараах зүйлсийг тусгана. Үүнд:
  - 6.6.1 Компанийн эзэмшлийн шугам сүлжээ, хамгаалалтын зурвасыг тодруулах.
  - 6.6.2 Техникийн нөхцөлд тусгагдсан холболтын цэгийг зөв сонгосон эсэх.
  - 6.6.3 Шугамын трасс болон дэд станцын байрлалтай ойртсон болон огтлолцсон цахилгаан шугам сүлжээг тодруулах.
- 6.7 Шугамын трасс болон дэд станц байрлах газарт бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчийн шугам сүлжээ байвал энэ тухай эзэмшигчтэй зөвшилцөхийг бичиж өгнө.
- 6.8 Мэдээллийн сангийн инженер нь өөрийн тодруулга хийсэн ажлын шугамын трасс, дэд станцын байршилтай хуудсыг өнгөтөөр хувилж аван, бүртгэл хөтлөн тодруулгын хамт архивлан хадгална.
- 6.9 Тодруулгын тодруулга хийсэн хуулбар зургийн хамт 2 жил Түгээх төв дээр хадгалан цаашид компанийн архивт өгч хадгалуулна.

## 7. ЗУРАГ ТӨСӨЛ ЗӨВШИЛЦӨХ

- 7.1 Зураг төслийн зөвшилцөл хийх ажиллагаа “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Техникийн бодлого зохицуулалтын хэлтэс зохион байгуулна.
- 7.2 Техникийн бодлого зохицуулалтын хэлтэс нь харъяа түгээх төвийн хийсэн тодруулгыг тусгасан, байршлын координаттай, зургийн тайлбартай ажлын зураг төслийг зөвшилцөнө.



- 7.3 Зөвшилцөл хийх ажлын зураг нь бусад инженерийн байгууламжийн байгууллагууд болон газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай зөвшилцсөн байна.
- 7.4 Бусад инженерийн байгууламжийн хамгаалалтын зурвас зөрчсөн болон, бусад хуулийн этгээдийн өмчлөх, эзэмших, ашиглах зөвшөөрөл бүхий газраар шугамын трасс тавигдсан болон дэд станц байрласан шалтгаанаас үүсэн гарах хариуцлагыг зургийн гүйцэтгэгч хүлээнэ.
- 7.5 Техникийн бодлого зохицуулалтын хэлтэс нь зөвхөн хүчин төгөлдөр техникийн нөхцлийн заалтууд болон сүлжээ байгуулалтын схем, объектын хүчин чадал, сүлжээ төлөвлөлтийн хэтийн төлөвт нийцэж байгаа талаар зөвшилцөл хийж дараах хуудсуудад дардас дарна. Үүнд:
  - 7.5.1 Шугам, дэд станцын трасс, байршил
  - 7.5.2 Дэд станц, хуваарилах байгууламжийн 0,4-35 кВ-ын зарчмын схем.
- 7.6 Шаардлагатай тохиолдолд дардсыг ажлын зураг төслийн бүрэлдэхүүний бусад хуудас дээр дарж болно.
- 7.7 Зөвшилцөх үед зураг төсөл нь хүчин төгөлдөр техникийн нөхцлийн заалтууд, сүлжээ байгуулалтын схем, объектын хүчин чадал, сүлжээ төлөвлөлтийн хэтийн төлөвтэй нийцэхгүй бол гүйцэтгэгчээр шаардлагатай өөрчлөлтүүдийг хийлгэнэ.
- 7.8 Тухайн объектын барилгын зураг болон тоноглолын найдвартай байдал түүний суурилуулалт, хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах шаардлагыг биелүүлсэн байдалд зураг төсөл зохиогчийн сонголтоор хийсэн асуудалд "УБЦТС" ТӨХК нь хариуцлага хүлээхгүй болно.
- 7.9 Зураг төслийн байгууллага нь ажлын зурагт зөвшилцөл хийсний дараа зураг төсөлд өөрчлөлт оруулбал дахин зөвшилцөл хийж болно.
- 7.10 Инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг оновчтой болгох үүднээс Техникийн бодлого зохицуулалтын хэлтсээс зураг төслийн байгууллагад зөвлөмж өгч болно.
- 7.11 Техникийн бодлого зохицуулалтын хэлтэс нь хэрэгцээтэй тохиолдолд зураг зөвшилцөх үйл ажиллагаанд бусад нэгжүүдийг татан оролцуулна.
- 7.12 УБЦТС ТӨХК-ийн Их засвар, Техник зохион байгуулалтын арга хэмжээ, Хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд болон Улсын төсвийн, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн олон нийтийн сүлжээнд суурилагдах тоног төхөөрөмж, шугам тоноглол, цахилгаан байгууламжийн зураг төслийг харъяа Түгээх төв, Хэрэглэгчдэд үйлчлэх төв болон холбогдох нэгжүүдтэй зөвшилцсөн байна. (Уг заалт нь 2019 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн техникийн зөвлөлийн хурлын шийдвэрээр нэмэгдэв.)
- 7.13 Техникийн бодлого зохицуулалтын хэлтэс нь дардас дарагдсан зураг төслийг техникийн асуудал эрхэлсэн дэд захирлаар баталгаажуулна.
- 7.14 Техникийн бодлого зохицуулалтын хэлтэс нь зөвшилцсөн трассын зураг, схем болон бусад шаардлагатай хуудсуудыг сканнердан электрон архивт хадгална. Электрон архивийг шаардлагатай ажилтнуудад харахаар эрх нээж байрлуулна.



## 8. ЗУРАГ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАРТ ТУСГАГДАХ ЗҮЙЛС

- 8.1 Компанийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх ажлуудад “Зураг төсөл боловсруулах даалгавар”-ыг боловсруулах, улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх ажлуудын зураг төслийн даалгаварт санал өгөх асуудлыг Техникийн бодлого зохицуулалтын хэлтэс хариуцна.
- 8.2 Зураг төсөлд өгөх зургийн даалгаварт дараах зүйлсийг тусгана:
  - 8.2.1. Зураг төслийг боловсруулах үндэслэл
  - 8.2.2. Барилга, байгууламжийн байршил
  - 8.2.3. Объектын бүрэлдэхүүн, хүчин чадал. (Шугам дэд станц, хуваарилах байгууламж, жижүүрийн байр, шугамын оруулга, гаргалга, шугамын урт, хэлхээний тоо, хүчдэл тус бүрээр бичнэ)
  - 8.2.4. Барилгын үндсэн бүтээц материал. (Шугамын тулгуур, дэд станцуудын барилгын үндсэн хийц, материал, хийцийг товч тодорхой бичнэ)
  - 8.2.5. Инженерийн хангамж. (Байгууламжын техникийн нөхцөлөөр тавигдах шаардлагууд)
  - 8.2.6. Цаашид өргөтгөх эсэх. (Өргөтгөл, өөрчлөлт, шинэчлэлт, техникийн тодорхойлолтыг тоноглол тус бүрээр)
  - 8.2.7. Зураг төслийн баримт боловсруулах үе шат, хугацаа.
  - 8.2.8. Барих хугацаа.
  - 8.2.9. Зургийн төслийн байгууллага
  - 8.2.10. Хөрөнгө оруулагч (захиалагч) байгууллага.
  - 8.2.11. Гүйцэтгэгч байгууллага. (Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендерээр сонгон шалгаруулна.)
  - 8.2.12. Онцгой нөхцөл
  - 8.2.13. Галын аюулгүй байдлын нөхцөл.
  - 8.2.14. Эдийн засгийн тооцоо (төсөв)
- 8.3 Техникийн бодлого зохицуулалтын хэлтсээс зургийн даалгавар боловсруулах ажилд холбогдох түгээх төв, алба хэлтсийн ажилтнуудыг татан оролцуулж болно.
- 8.4 Зургийн даалгаварыг Маягт ЗТ-2 ын дагуу боловсруулна.

“УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН ... ТТӨВ

ЗУРАГ ТӨСӨЛД ТОДРУУЛГА ХИЙСЭН ТОДОРХОЙЛОЛТ

20... оны... сарын...

1. Зураг төслийн захиалагч, объектийн байршил .....

2. Зураг төслийн гүйцэтгэгч .....

3. Зураг төслийн дугаар, нэр .....

4. Зураг төсөлд хийсэн тодруулга:

А. Ойртож буй шугам, тоноглол

Б. Огтлолцож буй шугам, тоноглол

**Жич:** Бусад иргэн, хуулийн этгээдийн шугам сүлжээг тухайн эзэмшигчтэй зөвшилцөх шаардлагатай.

Тодруулга хийсэн: Мэдээллийн сангийн инженер / /



ЗТБХБЯ-ны сайдын 2010 оны  
121 тоот тушаалын хавсралт.

**Өндөр хүчдлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд өртөөний зургийн  
төсөл боловсруулах даалгавар**

Дугаар...

Огноо

..... ХОТ

1. Зураг төслийг боловсруулах үндэслэл
2. Барилга, байгууламжийн байршил
3. Объектын бүрэлдэхүүн, хүчин чадал
4. Барилгын үндсэн бүтээц материал.
5. Инженерийн хангамж.
6. Цаашид өргөтгөх эсэх.
7. Зураг төслийн баримт боловсруулах үе шат, хугацаа.
8. Барих хугацаа.
9. Зургийн төслийнбайгууллага
10. Хөрөнгө оруулагч (захиалагч) байгууллага.
11. Гүйцэтгэгч байгууллага
12. Онцгой нөхцөл
13. Галын аюулгүй байдлын нөхцөл.
14. Эдийн засгийн тооцоо (төсөв)

Хянасан:...../ /  
Зөвшөөрсөн:...../ /  
Боловсруулсан:...../ /

“УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК  
ЗУРАГ ТӨСӨЛД ЗӨВШИЛЦӨЛ ХИЙСЭН ХУУДАС

Бүртгэлийн дугаар .....

20... оны... сарын .....

- 1. Зураг төслийн захиалагч, объектийн байршил .....
- 2. Зураг төслийн гүйцэтгэгч .....
- 3. Зураг төслийн дугаар, нэр .....
- 4. Зураг төсөлд өгсөн шаардлага

Зөвшилцсөн: ТБЗХ-ийн ..... /..... /

Бүртгэсэн: ТБЗХ-ийн ..... /..... /

Зураг төсөлд өгсөн шаардлагын биелэлт:

20... оны... сарын .....

Шаардлагын дугаар	Биелэлт

Биелэлт гаргасан: ..... /..... /